

ТЭЭВРИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь тээврийн төрлүүдийн харилцан уялдааг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Тээврийн тухай хууль тогтоомж

2.1. Тээврийн ерөнхий хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тээврийн төрлүүдийн тус тусын хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актуудаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хууль нь Монгол Улсын тээврийн төрлүүдийн харилцан уялдааг хангахтай холбогдсон дараах харилцааг зохицуулна:

3.1.1. өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр Монгол Улсын тээврийн төрлүүдийн харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа;

3.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэр, агаарын зайд хийгдэж буй дамжин өнгөрөх тээвэрлэлтийн үйл ажиллагаа;

3.1.3. Монгол Улсын тээврийн нэгдсэн сүлжээ, тээврийн логистик, болон тээврийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа;

3.1.4. гадаад далайд тээвэрлэлт гүйцэтгэх, далайн баялаг ашиглах, загас агнах үйл ажиллагаа эрхэлж буй Монгол Улсын бүртгэлтэй хөлөг онгоц.

3.1.5. Энэ хуульд зааснаас өөрөөр заасан болон Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаанд тавих төрийн хяналт, зохицуулалтын харилцааг Иргэний нисэхийн тухай хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “**тээвэрлэлт**” гэж тээврийн хэрэгслээр ачаа болон зорчигчийг нэг газраас нөгөө газарт шилжүүлэн зөөх үйлчилгээг;

4.1.2. “**тээвэр**” гэж тээвэрлэлт, тээврийн үйлдвэрлэл, тээврийн логистикийн үйлчилгээ, тэдгээрийн зохион байгуулалт, технологийн харилцан уялдаа бүхий цогц ажил үйлчилгээ;

4.1.3. **“тээврийн хэрэгсэл”** гэж ачаа, зорчигч тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автотээврийн хэрэгсэл, агаарын хөлөг, усан замын тээврийн хэрэгсэл, төмөр замын тээврийн хөдлөх бүрэлдэхүүн, дамжуулах хоолойг;

4.1.4. **“зорчигч”** гэж тээврийн хэрэгслээр үйлчлүүлж (зорчиж) буй хүнийг;

4.1.5. **“ачаа”** гэж тээврийн хэрэгслээр тээвэрлэж буй эд зүйлсийг;

4.1.6. **“тээвэрлэлтийн маршрут”** гэж эрх бүхий байгууллагаас тогтоосон эхлэх цэг, нэвтрэх боомт, дундын зогсоол, хүрэх цэг бүхий замыг;

4.1.7. **“тээвэрлүүлэгч”** гэж тээвэрлэлтийн ажил, үйлчилгээг хэрэглэгчийг;

4.1.8. **“тээвэрлэгч”** гэж тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхэлж байгаа этгээдийг;

4.1.9. **“дамжин өнгөрөх тээвэрлэлт”** гэж Монгол Улсын олон улсын чанартай хилийн боомтоор нэвтэрч, түүний нутаг дэвсгэр, агаарын зайгаар дамжин өнгөрөх тээвэрлэлтийг;

4.1.10. **“орон нутгийн тээвэрлэлт”** гэж Монгол Улсын нутаг дэвсгэр, агаарын зайд хийх тээвэрлэлтийг;

4.1.11. **“улс хоорондын тээвэрлэлт”** гэж Монгол Улсын хилийг нэвтрэн хийх тээвэрлэлтийг;

4.1.12. **“тээврийн дэд бүтэц”** гэж тээвэрлэлтийн үйл ажиллагааг үр ашигтай, аюулгүй, шуурхай гүйцэтгэхэд зориулагдсан бүх төрлийн зам, ачаа, зорчигчийн терминал, логистикийн төв болон тээврийн үйлдвэрлэл, үйлчилгээ, хяналт, зохицуулалт хийх зориулалт бүхий барилга, байгууламж, тоног төхөөрөмж бүхий байгууламжийг;

4.1.13. **“тээвэр зуучлалын үйлчилгээ”** гэж тээврийн нэг буюу хэд хэдэн төрлөөр ачаа, зорчигч тээвэрлэлтийг тээвэрлэгчдээр дамжуулан зохион байгуулж, үйлчлүүлэгчид хүргэх үйл ажиллагаа;

4.1.14. **“тээврийн үйлдвэрлэл”** гэж тээврийн хэрэгсэл, түүний эд анги, дэд бүтэц, тоног төхөөрөмж үйлдвэрлэх, угсрах ажлыг гүйцэтгэх болон техникийн ашиглалттай холбогдон гарах үйл ажиллагаа;

4.1.15. **“тээврийн логистик”** гэж тээвэрлэлтийг хамгийн бага зардлаар богино хугацаанд гүйцэтгэхтэй холбоотой цогц үйл ажиллагаа;

4.1.16. **“терминал, логистикийн төв”** гэж тээврийн логистикийн үйл ажиллагааг хангахад зориулагдсан зорчигчдыг хүлээн авах, үдэн гаргах, буулгах, суулгах, ачааг цуглуулах, хүлээн авах, хадгалах, боловсруулах ачиж буулгах, мэдээлэл дамжуулах ба солилцохтой холбогдсон цогц үйл ажиллагаанд зориулагдсан байгууламжийг;

4.1.17. **“тээврийн нэгдсэн сүлжээ”** гэж тээврийн төрлүүдийн дэд бүтцийн нэгдлийг;

4.1.18. **“тээврийн нэгдсэн сүлжээний төлөвлөлт”** гэж эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлага, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн тээврийн нэгдсэн сүлжээний хөгжлийг ойрын болон хэтийн хугацаанд төлөвлөх үйл ажиллагааг;

4.1.19. **“хөрөнгө оруулалтын төлөвлөлт”** гэж Монгол Улсын тээврийн нэгдсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, салбарын чадавхыг бэхжүүлэх, хөрөнгийн үр ашигтай, аюул осолгүй, найдвартай, тогтвортой ашиглагдах нөхцөлийг хангахад чиглэгдсэн дунд болон урт хугацааны хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийх;

4.1.20. **“тээврийн салбарын эрдэм шинжилгээ, судалгаа”** гэж Монгол Улсын тээврийн салбарын үр ашигтай, тогтвортой хөгжлийг хангах зорилго бүхий тээврийн салбарын дэвшилтэт техник, технологи судалгаа, шинжилгээний үндсэн дээр нэвтрүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг;

4.1.21. **“тээврийн салбарын шинжлэх ухаан, технологийн төсөл”** гэж эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг онол, арга зүйн өндөр түвшинд явуулж, хэрэгцээ, шаардлагыг хангасан үр дүн бий болгох, түүнийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, ашиглах үйл ажиллагааг төлөвлөсөн баримт бичгийг;

4.1.22. **“нийтийн тээвэр”** гэж нийтэд үйлчлэх зорилгоор эрх бүхий байгууллагаас тогтоосон үйлчилгээний чиглэл, маршрут, цагийн хуваарийн дагуу зохион байгуулалттай гүйцэтгэж буй зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг;

4.1.23. **“шинжлэн шалгах”** гэж тээвэрлэлтийн үйл ажиллагаанд гарч болзошгүй осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл цуглуулах, дүгнэлт хийх, түүнчлэн гарсан хэргийн шалтгааныг тогтоон аюулгүй ажиллагааны зөвлөмж бэлтгэх үйл ажиллагаа;

4.1.24. **“тусгай үүргийн тээвэрлэлт”** гэж дайны болон онц байдал зарласан, түүнчлэн улс орны аюулгүй байдлыг хангах мөн төрийн тусгай хамгаалалтын хүрээнд зохих журмын дагуу хийгдэж буй тээвэрлэлтийн үйл ажиллагааг;

4.1.25. **“тээврийн салбарын мэргэжлийн байгууллага”** гэж тээвэрлэлтийн үйл ажиллагааг мэргэжлийн үндсэн дээр удирдан зохион байгуулах, хяналт тавих, судалгаа шинжилгээ хийх үүрэг бүхий хуулийн этгээдийг;

4.1.26. **“тээврийн аюулгүй байдал”** гэж тээвэрлэлтийн болон тээвэр логистик, тээврийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хөндлөнгийн хууль бус үйл ажиллагаанаас хамгаалахтай холбогдсон цогцолбор арга;

4.1.27. **“тээврийн аюулгүй ажиллагаа”** гэж тээвэрлэлтийн болон тээвэр логистик, тээврийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөнд хохирол учруулахгүйгээр гүйцэтгэх нөхцөл байдал, чадварыг;

4.1.28. **“Тариф”** гэж тээвэрлэлтийн болон тээврийн үйлчилгээний үнэ, зохицуулалт, зохион байгуулах үйлчилгээний төлбөр, тээврийн дэд бүтэц ашигласны төлбөр, тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардал.

5 дугаар зүйл. Тээврийн үйл ажиллагааны үндсэн зарчим

5.1. Тээврийн салбарын үйл ажиллагаанд дор дурдсан зарчмыг баримтална:

- 5.1.1. тээврийн салбарын үйл ажиллагаа нэгдмэл байх;
- 5.1.2. тээврийн үйлчилгээ нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлага, зах зээлийн эрэлтийг хангасан байх;
- 5.1.3. үр ашигтай, тогтвортой үйл ажиллагааг хангасан байх;
- 5.1.4. үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангасан байх;
- 5.1.5. зах зээлийн өрсөлдөөнт нөхцөлийг бий болгох;

ХОЁРДУГААР БҮЛЭГ. **Тээврийн талаарх төрийн зохицуулалт**

6 дугаар зүйл. Тээврийн үйл ажиллагааны төрийн зохицуулалт

6.1. Тээврийн салбарыг үр ашигтай, тогтвортой хөгжүүлэх талаар баримтлах бодлогыг тодорхойлох, хууль эрх зүйн орчноор хангах, үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, нэгдсэн зохицуулалтаар хангах, хяналт тавих нь төрийн зохицуулалт болно.

6.2. Төрийн эрх бүхий байгууллагаар дамжуулан дараах удирдлагаар хангана:

6.2.1. шинжлэх ухаан, технологийн дэвшилд суурилсан, нийгэм, эдийн засгийн эрэлтийг хангахад чиглэгдсэн тээврийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, судалгаа, шинжилгээ хийх;

6.2.2. тээврийн салбарт эрх зүйн таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

6.2.3. нийгэм, эдийн засгийн эрэлтэд нийцсэн тээвэрлэлт болон түүнтэй холбогдох үйлчилгээний шинэ нөхцөлүүдийг бий болгох;

6.2.4. тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн эрх ашиг, зөрчигдөж байгаа эсэхэд хяналт тавих;

6.2.5. тээврийн салбарт олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх.

6.3. Тээврийн салбарын бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдлыг төрийн зүгээс хангана.

7 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх

7.1. Монгол Улсын Их Хурал тээврийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. төрөөс тээврийн талаар баримтлах нэгдсэн бодлогыг тодорхойлох, батлах;

7.1.2. өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар тээврийн талаар олон улсын гэрээ, хэлэлцээрийг соёрхон батлах;

7.1.3. тээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах;

8 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

8.1. Засгийн газар тээврийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1. тээврийн талаарх төрийн бодлого, тээврийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

8.1.2. тээврийн үр ашигтай, тогтвортой нэгдсэн сүлжээг хөгжүүлэх;

8.1.3. тээврийн салбарын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө батлах;

8.1.4. тээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах;

8.1.5. хүн амын нутагшил, суурьшлын онцлог, нийтийн тээвэр ба шуудан тээвэрлэлтийн хэрэгцээнээс шалтгаалан өрсөлдөх боломжгүй орон нутгийн тээврийн чиглэлд зорчигч, шуудан тээвэрлэлтийг зохих нөхөн төлбөр олгох нөхцөлтэйгээр гүйцэтгүүлэх;

8.1.6. тээврийн дэд бүтцийн газар эзэмшигчийг газрын төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх;

8.1.7. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

9 дүгээр зүйл. Тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

9.1. Тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. төрөөс тээврийн талаар баримтлах нэгдсэн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах;

9.1.2. тээврийн нийтлэг багц дүрэм, норм, нормативыг батлах;

9.1.3. тээврийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах эрх зүйн орчинг бүрдүүлэх;

9.1.4. аюултай ачаа тээвэрлэх болон тусгай үүргийн тээвэрлэлт гүйцэтгэх журмыг эрх бүхий байгууллагатай хамтран батлах;

9.1.5. тээврийн асуудлаар олон улсын үйл ажиллагаанд оролцох, улс хооронд тээвэрлэх болон дамжин өнгөрөх ачаа, зорчигчдын хэмжээ болон тээвэрлэлтийн аюулгүй байдал, үйлчилгээний чанарын шаардлагын талаар Засгийн газраас эрх олгосны дагуу холбогдох улстай гэрээ хэлцэл байгуулах;

9.1.6. нийгэм, эдийн засгийн эрэлтэд нийцсэн тээврийн үйлчилгээний шинэ төрлүүдийг хөгжүүлэх зохицуулалт хийх;

9.1.7. дамжин өнгөрөх тээвэрлэлтийн үйлчилгээний хураамж, навигацийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг тээврийн хэрэгслийн төрөл, даац, тээвэрлэлтийн зайнаас хамааруулан тогтоох;

9.1.8. тээврийн мэргэжлийн байгууллагын орон тоо, бүтэц, зохион байгуулалт, дүрмийг баталж, мэргэжлийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох;

9.1.9. Тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь олгогдсон эрхийнхээ хүрээнд тээврийн салбарын улс хоорондын харилцаанд гэрээ хэлцэл байгуулахдаа Монгол Улсын эрх ашгийг төлөөлнө.

9.1.10. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

10 дугаар зүйл. Тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

10.1.Тээврийн үйл ажиллагааны төрлөөс хамааран газрын тээврийн болон агаарын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байна.

10.2.Газрын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүтцэд хуурай замын болон усан замын тээврийн төрөл хамаарна.

10.3.Тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.3.1. төрөөс тээврийн талаар баримтлах нэгдсэн бодлого болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах;

10.3.2. дамжин өнгөрөх, улс хооронд, хот хоорондын тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах;

10.3.3. тээврийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;

10.3.4. тээврийн салбарт мөрдөх улсын стандартыг боловсруулж, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн эрх бүхий байгууллагаар батлуулах;

10.3.5. тээврийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангуулах ажлыг зохион байгуулах;

11 дүгээр зүйл. Орон нутгийн эрх үүрэг.

11.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь тээврийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1. нутаг дэвсгэртээ тээврийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангуулах;

11.1.2. төрөөс тээврийн талаар баримтлах нэгдсэн бодлого, төлөвлөгөөнд нийцүүлэн тухайн нутаг дэвсгэрт тээврийн талаар баримтлах бодлого, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;

11.1.3. тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллагатай хамтран нутаг дэвсгэртээ тээврийн улсын хяналт хэрэгжүүлэх;

11.1.4. орон нутгийн тээвэрлэлтийг тухайн нутаг дэвсгэрт зохион байгуулах, зохицуулах;

11.1.5. хүн амын нутагшил, суурьшлын онцлог, нийтийн зорчигч ба шуудан тээвэрлэлтийн хэрэгцээнээс шалтгаалан өрсөлдөх боломжгүй орон нутгийн тээврийн чиглэлд нийтийн зорчигч, шуудан тээвэрлэлтийг зохих нөхөн төлбөр олгох нөхцөлтэйгээр тээвэрлэгчтэй гэрээ хийж гүйцэтгүүлэх;

11.1.6. байгалийн гамшиг, сүйрэл, ослын хор уршгийг арилгах, тээврийн дэд бүтцийн хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангахад өөрийн эрх мэдлийн хүрээнд дэмжлэг үзүүлэх;

11.1.7. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

11.2. Тээврийн талаар төрөөс баримтлах бодлого, төлөвлөгөөг орон нутагт хэрэгжүүлэх болон энэхүү хуулийн 10.1 дүгээр зүйлд заасан эрхийг хэрэгжүүлэх үүргийг аймаг, нийслэлийн засаг дарга орон нутгийн тээврийн албаар дамжуулан хэрэгжүүлнэ.

12 дугаар зүйл. Тээврийн өмчлөл

12.1. Монгол Улсад тээврийн хэрэгслийн болон тээврийн дэд бүтцийн өмчлөлийн бүхий л хэлбэрийг хүлээн зөвшөөрнө.

12.2. Тээврийн хэрэгслийн болон тээврийн дэд бүтцийг өмчлөгч адил тэгш эрхтэй бөгөөд энэхүү эрх нь хуулиар хамгаалагдана.

12.3. Нийтийн хэрэгцээний авто зам, төмөр замын суурь бүтэц, нисэх буудал болон тээврийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор байгуулсан тоног төхөөрөмж, барилга байгууламж төрийн мэдэлд байна.

12.4. Нийтийн хэрэгцээний авто зам, төмөр замын суурь бүтэц, нисэх буудлын хөөрч, буух зурвасын газар нь төрийн өмчид байх бөгөөд тухайн газрыг газрын төлбөрөөс чөлөөлнө.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. Тээвэрлэлт

13 дүгээр зүйл. Тээврийн төрөл

13.1. Монгол Улсын тээврийн салбарыг дараах төрлөөр хөгжүүлнэ:

13.1.1. Хуурай замын тээвэр;

13.1.1.1. Авто замын тээвэр

13.1.1.1.2. Төмөр замын тээвэр

13.1.1.1.3. Хоолойн тээвэр

13.1.2. Агаарын тээвэр

13.1.2.1.1. Иргэний нисэх

13.1.3. Усан замын тээвэр

13.1.3.1.1. Усан замын тээвэр

13.1.3.1.2. Далай ашиглалт

13.2. Авто замын тээвэрт автотээврийн хэрэгслээр хийгдэж буй тээвэрлэлтийн бүх ажил үйлчилгээг хамруулна.

13.3. Төмөр замын тээвэрт төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнээр хийгдэж буй тээвэрлэлтийн ажил үйлчилгээ, мөн трамвай, метро, хөнгөн галт тэрэгний үйлчилгээг хамааруулна.

13.4. Хоолойн тээвэрт дамжуулах хоолой ашиглан хийгдэж буй тээвэрлэлтийн ажил үйлчилгээ, мөн татлага, туузан дамжуурга ашиглан хийгдэж буй тээвэрлэлтийн ажил үйлчилгээг хамааруулна.

13.5. Агаарын тээвэрт агаарын хөлгөөр хийгдэж буй тээвэрлэлтийн ажил үйлчилгээг хамруулна.

13.6. Усан замын тээвэрт дотоодын гол мөрөн, нуурын усанд усан замын тээврийн хэрэгслээр хийгдэж буй тээвэрлэлтийн үйлчилгээг хамруулна.

13.7. Далай ашиглалтад Монгол Улсын Төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцоор тээвэрлэлт гүйцэтгэх, далайн баялаг олборлох, загас агнах зэрэг үйл ажиллагааг хамруулна.

13.8. Монгол Улсад шинээр хөгжүүлэх тээврийн төрлийг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, тээврийн талаар төрөөс баримтлах бодлоготой нийцэж буй эсэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байдал, үр ашиг зэргийг судлан, нийцэж буй тохиолдолд бодлогоор дэмжин хөгжүүлэхийг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

13.9. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, дэвшилтэд техник, технологид суурилсан тээврийн бүхий л төрлийг хөгжүүлэхийг төр бодлогоор дэмжинэ.

14 дугаар зүйл. Тээвэрлэлтийн үйл ажиллагаа

14.1. Тээвэрлэлтийн үйл ажиллагааг хамрах хүрээгээр нь дараах байдлаар ангилна:

14.1.1. Орон нутгийн тээвэрлэлт

14.1.2. Улс хоорондын тээвэрлэлт

14.1.3. Олон улсын тээвэрлэлт

14.1.4. Дамжин өнгөрөх тээвэрлэлт

14.2. Орон нутгийн тээвэрлэлтэд тухайн аймаг, нийслэл, сумын нутаг дэвсгэр болон тэдгээрийн хооронд хийгдэж буй тээвэрлэлтийг хамруулна.

14.3. Улс хоорондын тээвэрлэлтэд Монгол Улсын хуурай зам, усан зам, агаарын хилийг нэвтрэн хөрш орнуудтай хийгдэж буй тээвэрлэлтийг хамруулна.

14.4. Олон улсын тээвэрлэлтэд нэгээс илүү улсын нутаг дэвсгэр, агаарын зайг ашиглан хийх тээвэрлэлтийг хамруулна.

14.5. Дамжин өнгөрөх тээвэрлэлтэд Монгол Улсын олон улсын чанартай хилийн боомтоор нэвтэрч, түүний нутаг дэвсгэр, агаарын зайгаар дамжин өнгөрөх тээвэрлэлтийг хамруулна.

14.6. Дамжин өнгөрөх тээвэрлэлтэд дараах зарчмыг баримтална:

14.6.1. дамжин өнгөрөх тээвэрлэлтийг зөвхөн хэлэлцэн тохирогч талуудтай, тохиролцсон чиглэл, маршрут, боомтоор зохион байгуулна;

14.6.2. дамжин өнгөрөх тээвэрлэлт нь сэлгэн тээвэрлэх, хадгалах, нэгтгэх, тээврийн төрлийг өөрчлөх, эсхүл эдгээр үйлдлийг гүйцэтгэхгүйгээр дамжин өнгөрөх байдлаар хийгдэнэ;

14.6.3. дамжин өнгөрөх тээвэрлэлт гүйцэтгэхдээ хэлэлцэн тохирогч талуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрийг удирдлага болгоно;

14.6.4. Монгол Улсын нутаг дэвсгэр, агаарын зайд дамжин өнгөрөх тээвэрлэлт гүйцэтгэх журам, нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэхийг хориглосон барааны жагсаалтыг Засгийн газар тогтооно;

14.7. Тээвэрлэлтийн үйлчилгээг зөвхөн хууль тогтоомжийн дагуу эрх, зөвшөөрөл авсан, бүртгүүлсэн иргэн аж ахуйн нэгж байгууллага гүйцэтгэнэ.

15 дугаар зүйл. Тээвэрлэгчийн эрх, үүрэг

15.1. Тээвэрлэгч нь дараах эрхтэй:

15.1.1. тээвэрлэгч нь тээврийн дэд бүтцийг тээвэрлэлт гүйцэтгэхэд саадгүй байхыг шаардах, дэд бүтцийн ашиглалтын нөхцөл хангаагүйгээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;

15.1.2. тээвэрлэлтийн гэрээгээр хүлээсэн нөхцөл, тээвэрлэлтийн үнэ тарифыг тээвэрлүүлэгчээс шаардах;

15.1.3. хууль тогтоомжид заасан бусад эрх.

15.2. Тээвэрлэгч нь дараах үүрэгтэй:

15.2.1. тээвэрлэлтийн үйлчилгээ, үнэ тарифын талаарх үнэн зөв мэдээллээр тээвэрлүүлэгчийг хангах;

15.2.2. техникийн болон аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэлтийг гүйцэтгэх;

15.2.3. зорчигч болон ачаа тээшийг аюулгүй, шуурхай тээвэрлэх, осол саатлын үед тэдгээрийг авран хамгаалах, зохих байгууллагад шуурхай мэдэгдэх;

15.2.4. тээврийн үйлчилгээ эрхлэхдээ тээвэрлэлтийн маршрут, цагийн хуваарийн дагуу шуурхай үйлчилгээ үзүүлэх;

15.2.5. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

16 дүгээр зүйл. Тээвэрлүүлэгчийн эрх, үүрэг

16.1. Тээвэрлүүлэгч нь дараах эрхтэй

16.1.1. тээвэрлэлтийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг бүрэн хангасан тээврийн хэрэгслээр үйлчлүүлэх, шаардлага хангаагүй зориулалтын бус тээврийн хэрэгслээр үйлчлүүлэхээс татгалзах;

16.1.2. өмчлөлийн хэлбэр, төрлөөс үл хамааран тээврийн хэрэгслээр зорчихдоо хууль тогтоомжоор олгосон хөнгөлөлтийг эдлэх;

16.1.3. тээврийн үйлчилгээг тогтоосон чиглэл, үйлчилгээний цагийн хуваарь баримтлахыг тээвэрлэгчээс шаардах;

16.1.4. хууль тогтоомжид заасан бусад эрх.

16.2. Тээвэрлүүлэгч нь дараах үүрэгтэй

16.2.1. зорчигч болон ачаа тээшийг тээвэрлэхэд харилцан тохиролцооны үндсэн дээр байгуулсан гэрээний хөлс төлөх;

16.2.2. тээвэрлэлтийн дүрэм, журмыг сахих;

16.2.3. зорчигч нь иргэний үнэмлэх болон түүнтэй адилтгах бусад баримт бичгийг, биедээ авч явах, тэдгээрийг шалгах эрх бүхий хүмүүсийн анхны шаардлагаар шалгуулах;

16.2.4. ачааны савлалт, баглаа, боодол, бэхэлгээг стандартын дагуу хийж, тээвэрлэх, хадгалах нөхцөл болон илгээх чиглэлийн тухай мэдээллээр тээвэрлэгчийг хангах;

16.2.5. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

17 дүгээр зүйл. Тээврийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа

17.1. Тээврийн дэд бүтцийн аюулгүй байдлыг өмчлөгч, эзэмшигч хариуцах бөгөөд аюулгүй байдлыг хангаагүй дэд бүтэц ашиглан тээвэрлэлт гүйцэтгэхийг хориглоно.

17.2. Тээвэрлэлтийн аюулгүй байдлыг тээвэрлэгч хариуцах бөгөөд аюулгүй байдлыг хангаагүй, зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэлт гүйцэтгэхийг хориглоно.

17.3. Тээврийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа нь тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн болон тээврийн бусад үйлчилгээ хэрэглэгчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн нэгдмэл байна.

17.4. Тээврийн хэрэгсэл нь аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан, хүн ам, хүрээлэн буй орчинд, хөдөлмөр хамгааллын хэм хэмжүүр, техникийн нөхцөл, стандартын шаардлагыг хангасан байх ба хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн байна.

17.5. Тээвэрлэлтийн аюулгүй байдал нь аюулгүй, ая тухтай, шуурхай, хүртээмжтэй тээвэрлэлтийн нөхцөл бүрдсэн байдлаар хангагдана.

17.6. Тээврийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тээврийн төрөл тус бүрийн стандартаар тогтооно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Тээврийн үйлчилгээ

18 дугаар зүйл. Тээврийн үйлчилгээний төрөл

18.1. Тээврийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна.

18.1.1. тээвэрлэлтийн үйлчилгээ

18.1.2. логистикийн үйлчилгээ

18.1.3. тээврийн үйлдвэрлэл

18.2. Тээвэрлэлтийн үйлчилгээнд тээврийн хэрэгсэл ашиглан ачаа, зорчигч тээвэрлэх үйлчилгээ хамаарна.

18.3. Логистикийн үйлчилгээнд ачаа, зорчигч тээвэрлэхтэй холбогдсон хүлээн авах, боловсруулах, хадгалах, хуваарилах, хүлээлгэн өгөх, зуучлах, даатгах зэрэг үйлчилгээнүүд хамаарна.

18.4. Тээврийн үйлдвэрлэлд тээврийн хэрэгсэл болон түүний эд анги, үйлдвэрлэх, угсрах, болон техник ашиглалттай холбогдон гарах үйлчилгээ хамаарна.

19 дугаар зүйл. Тээвэр зуучлалын үйлчилгээ

19.1. Тээвэр зуучлалын үйлчилгээг дараах байдлаар ангилна:

19.1.1. Олон улсын тээвэр зуучлалын үйлчилгээ

19.1.2. Дотоодын тээвэр зуучлалын үйлчилгээ

19.2. Тээвэр зуучлалын үйлчилгээг зохих байгууллагаас эрх олгогдсон хуулийн этгээд эрхэлнэ.

19.3. Тээвэр зуучлалын үйлчилгээний эрх олгох, тавигдах нөхцөл шаардлагыг тээврийн зохицуулах хороо тогтооно.

19.4. Тээвэр зуучлалын үйлчилгээ эрхлэгч нь тээвэрлүүлэгчийн ачаа, зорчигчийг илгээх цэгээс хүрэх цэгт нэг буюу хэд хэдэн тээвэрлэгчээр дамжуулан тогтоосон хугацаанд хүргэж үйлчилнэ.

19.5. Тээвэр зуучлалын үйлчилгээг салбар агентаар харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

20 дүгээр зүйл. Тээвэр логистикийн үйлчилгээ

20.1. Тээвэрлэлтийн үйлчилгээг аюулгүй, ая тухтай, шуурхай, хямд зардлаар гүйцэтгэхийн тулд зөвхөн тээврийн логистикийн төвүүдээр дамжуулан тээврийн үйлчилгээг үзүүлнэ.

20.2. Ачаа тээврийн логистикийн төв нь өөрийн нэгдсэн сүлжээг ашиглан дотоодын, экспорт, импортын болон дамжин өнгөрөх ачааг хүлээн авах, хүлээлгэн өгөх, хадгалах, шилжүүлэн ачих, мэдээллийн сан бүрдүүлэх болон зохион байгуулалтын бусад үйлчилгээг үзүүлнэ.

20.3. Зорчигч тээврийн логистикийн төв нь зорчигчид ая тухтай үйлчилгээ үзүүлэх, тээвэрлэлтийн үйлчилгээг оновчтой зохион байгуулах үйлчилгээг үзүүлнэ.

20.4. Тээврийн логистикийн үйлчилгээг зохих хуулиар зохицуулна.

21 дугаар зүйл. Тээврийн үйлдвэрлэл

21.1. Тээврийн үйлдвэрлэлийг хүчин чадал, зориулалтын хувьд дараах байдлаар ангилна:

21.1.1. Бүх төрлийн тээврийн хэрэгсэл, дэд бүтцийн тоног төхөөрөмжийн угсралт, үйлдвэрлэл;

21.1.2. Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн эд анги, дагалдах хэрэгсэл, ашиглалтаас үүдсэн бусад үйлдвэрлэл;

21.1.3. Тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ.

21.2. Тээврийн үйлдвэрлэлийг техникийн стандарт, шаардлагыг хангасан хуулийн этгээд эрхэлнэ.

21.3. Тээврийн үйлдвэрлэл эрхлэгч нь тухайн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний ашиглалтын аюулгүй ажиллагаа, хэрэглэгчдийн аюулгүй байдлын баталгааг хариуцна.

21.4. Монгол Улсад үйлдвэрлэсэн, угсарсан тээврийн хэрэгсэлд үйлдвэрлэгчийн таних тэмдэг, улсын бүртгэлийн дугаар олгох журмыг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

22 дугаар зүйл. Даатгал

22.1. Тээвэрлэгч нь болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тээвэрлэлтийн үйл ажиллагааны улмаас бусдад учруулсан хохирлын үр дагаврыг шуурхай арилгах зорилгоор тээвэрлэгчийн хариуцлагын даатгалд заавал хамрагдсан байна.

22.2. Тээврийн хэрэгслээр зорчигч нь өөрийн амь насыг даатгуулах үүрэгтэй.

22.3. Ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч нь даатгалаар хүлээх хариуцлагын үнэлгээнээс илүү үнэлгээ бүхий ачаа тээвэрлэхийг хориглоно.

22.4. Тээвэрлэгчийн хариуцлагын үнэлгээний индексийг Даатгалын тухай хуулиар тогтооно.

ТАВДУГААР БҮЛЭГ. Бодлого, төлөвлөлт

23 дүгээр зүйл. Тээврийн талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлого, төлөвлөлт

23.1. Тээврийн салбарын тогтвортой хөгжлийг хангах, эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилт бүхий тээврийн талаар төрөөс баримтлах урт, дунд, богино хугацааны нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй байна.

23.2. Тээврийн нэгдсэн бодлого, төлөвлөлт нь улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад үндэслэн, тээврийн салбарын үр ашигтай, тогтвортой хөгжлийг хангасан байна.

23.3. Тээврийн дэд салбарууд болон орон нутгийн тээврийн сүлжээ, тээвэрлэлтийг хөгжүүлэх бодлого, төлөвлөлт нь нэгдсэн бодлогын зорилго, зорилтыг хангахад чиглэгдэнэ.

24 дугаар зүйл. Баримтлах зарчим

24.1. Тээврийн талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлого, төлөвлөгөөнд дараах зарчмыг баримтална:

24.1.1. тээврийн салбарын тогтвортой хөгжил, үр ашгийг нэмэгдүүлэх, тээврийн төрлүүдийн хоорондын уялдаа холбоог хангахад чиглэсэн байна;

24.1.2. улс орны нийгэм эдийн засгийг хөгжүүлэх бодлого төлөвлөгөөтэй уялдсан байна;

24.1.3. тээврийн дэд салбаруудын нэгдмэл байдлыг хангасан байна;

24.1.4. тээврийн төрлүүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна;

24.1.5. тээврийн эрэлт хэрэгцээг хангахад тээврийн төрлүүдийн зохистой харьцааг хангасан байна.

25 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт

25.1. Тээврийн талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг уялдуулан хийнэ.

25.2. Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг боловсруулахдаа санхүүгийн олон эх үүсвэрээс санхүүжих боломжид тулгуурлана.

25.3. Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн хэрэгжилтийг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хангана.

25.4. Хөрөнгө оруулалтад төр хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа, уян хатан тарифын бодлого, чөлөөт өрсөлдөөнийг дэмжинэ.

26 дугаар зүйл. Эрдэм шинжилгээ, судалгаа

26.1. Тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд тээврийн эрдэм шинжилгээ судалгааны байгууллага ажиллана.

26.2. Тээврийн эрдэм шинжилгээ судалгааны байгууллага нь дараах эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх үйл ажиллагаа эрхэлнэ:

26.2.1. нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зорилтыг шийдвэрлэхэд тээврийн салбарын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;

26.2.2. нийгмийн эрэлт хэрэгцээнд чиглэсэн суурь судалгааг хөгжүүлэх замаар салбарын шинжлэх ухаан үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх, үр дүнг дээшлүүлэх шинжлэх ухаан, технологийн төсөл боловсруулах;

26.2.3. тээврийн салбарын хөгжлийн хэтийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлохтой холбогдсон судалгаа хийх;

26.2.4. нийгэм болон иргэдийн эрэлт хэрэгцээг хангах, байгаль орчинд ээлтэй тээврийн нэгдсэн системийг бүрдүүлэх;

26.2.5. дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэх сорилт, туршилт хийх;

26.2.6. тээврийн салбарт мөрдөх стандарт, норм, норматив, дүрэм, журам боловсруулах;

26.2.7. тээврийн салбарын өрсөлдөх чадварын үнэлгээ, судалгаа.

26.3. Тээврийн эрдэм шинжилгээ судалгааны байгууллагын үйл ажиллагааны журам, бүтэц, судалгааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох асуудал Шинжлэх ухаан, технологийн тухай хуулиар зохицуулагдана.

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. Тээврийн дэд бүтэц

28 дугаар зүйл. Тээврийн дэд бүтцийн бүрэлдэхүүн

28.1. Тээврийн дэд бүтэц нь тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн эрх, үүргийг хангахад чиглэгдсэн олон улсын болон үндэсний тээврийн нэгдсэн сүлжээнд холбогдсон байна.

28.2. Авто замын тээврийн дэд бүтцэд авто зам, замын байгууламж, ачаа зорчигч үйлчилгээний цогцолбор хамаарна.

28.3. Агаарын тээврийн дэд бүтцэд агаарын зам, агаарын хаалга, нисэх буудал, аэродром хамаарна.

28.4. Төмөр замын тээврийн дэд бүтцэд суурь бүтэц, ачаа зорчигч үйлчилгээний цогцолбор хамаарна.

28.5. Усан замын тээврийн дэд бүтцэд суурь бүтэц, ачаа зорчигч үйлчилгээний цогцолбор хамаарна.

28.6. Хоолойн тээврийн дэд бүтцэд суурь байгууламж, ачаа тээврийн үйлчилгээний цогцолбор хамаарна.

29 дүгээр зүйл. Тээврийн үйлчилгээний зангилаа төв

29.1. Тээврийн логистикийн төв нь үйлдвэрлэл, үйлчилгээний бүсэд ойрхон, эдийн засгийн ач холбогдол бүхий тээврийн нэгдсэн сүлжээний зангилаа хэсэгт байрласан, тээврийн логистикийн нэгдсэн сүлжээнд холбогдсон байна.

29.2. Тээврийн логистикийн төв нь үйлчилгээний төрлөөс хамааран дараах төрөлтэй байна:

29.2.1. зорчигчийн

29.2.2. ачааны

29.2.3. ачаа, зорчигчийн холимог

29.3. Тээврийн логистикийн төв нь үйлчлэх хүрээнээсээ хамааран Олон улсын, бүс нутгийн, орон нутгийн гэсэн төрөлтэй байна.

29.4. Тээврийн логистикийн төвийн байршлыг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

29.5. Тээврийн логистикийн төвийн үйл ажиллагаа, үйлчилгээнд тавигдах шаардлагыг стандартаар тогтоох бөгөөд дараах зэрэглэлтэй байна:

29.5.1. нэгдүгээр зэрэглэлийн тээврийн логистикийн төв нь олон улсын болон бүс нутгийн тээврийн логистикийн сүлжээнд холбогдсон, хоёр болон түүнээс дээш тээврийн төрлийн үйлчилгээнд зориулагдсан, олон улсын, бүс нутгийн, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлнэ;

29.5.2. хоёрдугаар зэрэглэлийн тээврийн логистикийн төв нь олон улсын, бүс нутгийн, орон нутгийн тээврийн логистикийн сүлжээнд холбогдсон тээврийн нэг төрлийн үйлчилгээнд зориулагдсан, олон улсын, бүс нутгийн, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлнэ;

29.5.3. гуравдугаар зэрэглэлийн тээврийн логистикийн төв нь орон нутгийн тээврийн логистикийн сүлжээнд холбогдсон тээврийн нэг төрлийн үйлчилгээнд зориулагдсан, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлнэ;

30 дүгээр зүйл. Тээврийн ухаалаг систем

30.1. Тээврийн салбарын үр ашиг, аюулгүй ажиллагааг сайжруулах зорилгоор мэдээллийн технологид суурилсан тээврийн удирдлага, хяналт, зохицуулалтын нэгдсэн систем буюу тээврийн ухаалаг системийг бүрдүүлнэ.

30.2. Тээврийн ухаалаг систем нь тээвэрлэлтийн аюулгүй байдал, үр ашгийг нэмэгдүүлэх, нэгдсэн удирдлага, хяналт, зохицуулалтаар хангах, мэдээлэл солилцоход чиглэгдэнэ.

30.3. Логистикийн төвүүд нь үйлчлэх хүрээнээсээ хамааран үндэсний болон бүс нутгийн логистикийн цахим сүлжээнд заавал холбогдсон байна.

ДОЛДУГААР БҮЛЭГ. Тээврийн зохицуулах хороо

31 дугаар зүйл. Тээврийн зохицуулах хороо

31.1. Өмчийн төрөл харгалзахгүйгээр аж ахуйн нэгж, байгууллага, иргэн зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, тээвэр, логистикийн уялдаа холбоог хангах, тээврийн нэгдсэн сүлжээ, дэд бүтэц, байгууламжийг ашиглах, хамтран ашиглах харилцааг зохицуулах, үйл ажиллагаа эрхлэх эрх, зөвшөөрөл олгох, дээрх асуудлаар мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй Тээврийн зохицуулах хороо /цаашид "Зохицуулах хороо" гэх/ ажиллана.

31.2. Зохицуулах хороо нь дарга, тээврийн дэд салбар бүрийн төлөөлөл бүхий орон тооны 3, орон тооны бус 6 гишүүнээс бүрдэнэ.

31.3. Зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилно.

31.4. Зохицуулах хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна. Зохицуулах хорооны гишүүдийн анхны томилгоог 2, 4, 6 жилээр хийж, цаашид 6 жилийн хугацаагаар томилно.

31.5. Зохицуулах хорооны дарга, гишүүдийг нэг удаа улируулан томилж болно.

31.6. Тээврийн салбарт мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, дараах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг Зохицуулах хорооны дарга, гишүүнээр томилно:

31.6.1. тээврийн инженер, тээврийн эрх зүйч, тээврийн эдийн засагч, тээврийн удирдлагын чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн, мэргэшсэн, ажлын дадлага, туршлагатай;

31.6.2. зохицуулах хорооны дарга, гишүүн нь тээврийн үйлчилгээ эрхлэгчийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаар эзэмшигч, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд байж болохгүй.

31.7. Зохицуулах хороо нь ажлын албатай байх ба хорооны дэргэд хэрэглэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тэнцүү тооны төлөөллөөс бүрдсэн зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллуулж болно.

31.8. Зохицуулах хороо нь ажлын албатай байх ба ажлын албаны орон тоо, дүрмийг тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөж, Ерөнхий сайд батална.

31.9. Зохицуулах хороо нь дараах эх үүсвэрээс санхүүжнэ:

31.9.1. тээврийн үйл ажиллагаа эрхлэх эрх, зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлс;

31.9.2. агаарын навигацийн үйлчилгээний болон дамжин өнгөрөх тээврийн үйлчилгээний төлбөрийн 5-н хувь.

31.10. Зохицуулах хорооны жилийн төсвийг Ерөнхий Сайд батална. Зохицуулах хороо нь ажлын тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ерөнхий сайд болон Тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хагас бүтэн жилээр тайлагнана.

31.11. Зохицуулах хороо нь санхүүгийн тайлангаа жил бүр аудитаар баталгаажуулж, нийтэлнэ.

32 дугаар зүйл. Зохицуулах хорооны үйл ажиллагааны зарчим

32.1. Хороо үйл ажиллагаандаа дараах зарчмыг удирдлага болгоно.

32.1.1. бие даасан, бусдын нөлөөнд үл автах

32.1.2. ил тод, нээлттэй байх, үл ялгаварлах

32.1.3. тээврийн үйлчилгээний зах зээлийн тогтвортой байдлыг хангах

32.1.4. тээврийн үйлчилгээ эрхлэгч болон тээврээр үйлчлүүлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах

33 дүгээр зүйл. Зохицуулах хорооны бүрэн эрх

33.1. Зохицуулах хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

33.1.1. тээврийн талаар төрөөс баримталж буй бодлогын талаар санал гаргах, эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах;

33.1.2. бүрэн эрхийнхээ хүрээнд дүрэм, журам, заавар баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих;

33.1.3. тээврийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор шаардлагатай шалгуур үзүүлэлт тогтоох;

33.1.4. тээврийн үйл ажиллагаа эрхлэх эрх, зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

33.1.5. тээврийн үйл ажиллагаа эрхлэх эрх, зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоох, биелэлтэд хяналт тавих;

33.1.6. тээврийн аюулгүй ажиллагаа, тээврийн аюулгүй байдлын нөхцөл, шаардлагыг тогтоох, эрх бүхий мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн баталгаажуулах;

33.1.7. тээврийн зах зээлийн өрсөлдөөний нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, шударга өрсөлдөөнийг бүрдүүлэх зохицуулалт хийх;

33.1.8. тээврийн нэгдсэн сүлжээ ашиглах, хамтран ашиглах гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журмыг батлах;

33.1.9. тээврийн нэгдсэн маршрут, цагийн хуваарийн төлөвлөлтийг батлах, хэрэгжилтэд хяналт тавьж, зохицуулалт хийх;

33.1.10. тээврийн үнэ тарифыг тогтоох аргачлал, журмыг батлах;

33.1.11. үнэ тарифын үндэслэлийг хянах, зохицуулалт хийх;

33.1.12. тээврийн үйл ажиллагаа эрхлэх эрх, зөвшөөрөл эзэмшигчид үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох;

33.1.13. тээврийн үйл ажиллагаа эрхлэх эрх, зөвшөөрөл эзэмшигч хоорондын болон үйлчлүүлэгч хооронд гарсан маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан шийдвэрлэх;

33.1.14. тээврийн салбарт шударга бус өрсөлдөөн үүсэхээс сэргийлэх зорилгоор тариф, бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээ, гэрээний өөрчлөлтийг хянаж, санал, дүгнэлт гаргах;

НАЙМДУГААР БҮЛЭГ. Хяналт шалгалт

34 дугаар зүйл

34.1.Тээврийн салбарын улсын хяналтыг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх хяналтын алба, тээврийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

34.2.Тээврийн салбарын хяналтыг хэрэгжүүлэх байгууллага, улсын байцаагч нь тээврийн үйлчилгээнд мөрдөж буй хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм, журам, стандарт, норм, нормативын хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, буруутай үйлдлийг илрүүлж таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх, учирсан хохирлыг арилгуулах арга хэмжээ авах үүрэгтэй ажиллана.

34.3.Тээврийн хяналтын улсын дүрмийг Засгийн газар батална.

34.4.Тээвэрлэлтийн үйлчилгээг хэрэглэгч, нийгмийн эрх ашигт нийцүүлэхтэй холбогдон хяналтыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

34.4.1. тээвэрлэлтийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулахтай холбогдсон хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх үндсэн дээр гаргасан бусад шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

34.4.2. техник, төхөөрөмж, байгууламж болон тээвэртэй холбоотой ажил, үйлчилгээ, технологийн горим нь тээврийн аюулгүй байдал, стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг өмчийн хэлбэр, байршил харгалзахгүйгээр шалгах;

34.4.3. тээврийн хэрэгслийн техникийн хяналт, нийтийн тээвэр эрхлэх үүргийн биелэлтийг хангуулах;

34.4.4. улсын захиалга, даалгавар, цаг үеийн шуурхай тээвэрлэлтэд хяналт тавих;

34.4.5. нийтийн тээврийн чиглэл, цагийн хуваарь, үйлчилгээний журмыг мөрдүүлэх;

34.4.6. тээврийн хэрэгслийн ашиглалтын шаардлага, тээвэрлэлтийн нөхцөлийг хангуулах, тээвэрлэлтийн баримт бичгийн бүрдүүлэлтийг зохих шаардлагын дагуу гүйцэтгүүлэх;

34.4.7. тээвэрлэгч, тээвэрлүүлэгч, зорчигчийн үүргийн биелэлтийг хангах;

34.4.8. тээврийн дэд бүтэц, шатахуун, тосолгооны материалын чанар нь тээвэрлэлтийн аюулгүй байдалд нөлөөлж болох зөрчлөөс урьдчилан сэргийлэх.

34.4.9. тодорхой ангиллын авто замын техникийн шаардлагад нийцэхгүй байгаа тээврийн хэрэгслийг авто замын хөдөлгөөнд оролцохыг хориглох;

34.4.10. тээврийн дэд бүтэц барих, засварлах, арчлах, хамгаалах, ашиглахтай холбогдсон дүрэм, журам, норм, технологи, стандартын хэрэгжилтийг шалгах;

34.5. Хяналтын алба нь улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч, улсын байцаагчаас бүрдэнэ.

34.6. Улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

34.7. Улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан байцаагчийн бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

34.7.1. хяналтыг хэрэгжүүлэхдээ тээврийн хэрэгслийг түр зогсоож шалгах, шаардлагатай тохиолдолд тээврийн хэрэгслийг түр саатуулах;

34.7.2. тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх;

34.7.3. ачаа, чингэлэг, ачаан тээш, тээшний жин болон тээврийн бичиг баримт, түүнтэй холбогдох бусад мэдээллийг шалгах;

34.7.4. хууль тогтоомж зөрчсөнөөс гарсан хохирлын хэмжээг тогтоох, хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардах;

34.7.5. тээврийн дэд бүтцэд гарсан эвдрэл гэмтэл, зам тээврийн ослын шалтгааныг судлах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, шаардлагатай нөхцөлд мэргэжлийн дүгнэлт гаргах.

34.8. Улсын байцаагчаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд өгсөн үүрэг, тавьсан шаардлагыг холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэн заавал биелүүлэх үүрэгтэй.

34.9. Улсын байцаагч нь дүрэмт хувцас, албан үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай техник хэрэгсэл хэрэглэнэ.

35 дугаар зүйл. Тээврийн үйлчилгээний осол зөрчлийг шинжлэн шалгах

35.1. Тээврийн үйлчилгээнд гарч болзошгүй осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл цуглуулах, дүгнэлт хийх, түүнчлэн гарсан хэргийн шалтгааныг тогтоон аюулгүй байдлын зөвлөмж бэлтгэх зорилгоор осол хэргийг шинжлэн шалгах үйл ажиллагаа явуулна.

35.2. Тээврийн үйлчилгээнд гарсан осол, зөрчлийн урьдчилсан нөхцөл үүссэн тухай асуудлыг шинжлэн шалгах, ангилах, бүртгэх ажиллагааг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх шинжлэн шалгах алба гүйцэтгэнэ.

35.3. Тээврийн осол, зөрчлийг шинжлэн шалгах чиглэл, үйл ажиллагааг Тээврийн осол зөрчлийг шинжлэн шалгах тухай хуулиар зохицуулна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ.

Бусад зүйл.

36 дугаар зүйл. Тээврийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

36.1. Тээврийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх захиргааны хариуцлагыг тээврийн төрлийг нарийвчлан зохицуулсан тус тусын хуулиар тогтооно.

36.2. Тээврийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд захиргааны шийтгэл ногдуулсан нь иргэний хууль тогтоомжид заасан бусад төрлийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

37 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

37.1. Энэ хуулийг 2016 оны . . . дугаар сарын . . . –ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

37.2. Энэ хуулийн 35 дугаар зүйлийг Тээврийн осол, зөрчлийг шинжлэн шалгах тухай хууль батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

- Үндсэн хууль, энэ хууль
- **Тээврийн ерөнхий хууль /шинээр/**
- Автотээврийн тухай хууль
- Авто замын тухай хууль,
- Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль,
- Далай ашиглах тухай хууль
- Усан замын тээврийн тухай хууль
- Иргэний нисэхийн тухай хууль
- Төмөр замын тээврийн тухай хууль
- **Хоолойн тээврийн тухай хууль /шинээр/**
- **Логистикийн тухай хууль /шинээр/**